

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 4 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны гуравдугаар сарын 15-ны 15 цаг 26 минутад эхэлж, 14 цаг 45 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын өрөөнд болж, нийт 1 цаг 19 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Цагаандэлгэр, Адаацаг сумдын Соёлын төвийн эрхлэгч, Эрдэнэдалай сумын сум дундын эмнэлгийн эрхлэгч, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай	Цагаандэлгэр, Адаацаг сумдын Соёлын төвийн эрхлэгч, Эрдэнэдалай сумын сум дундын эмнэлгийн эрхлэгч, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зарлаж, бүртгэлийг 2016 оны 04 сарын 04-ны өдөр, шалгалтыг 04 сарын 05-06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.
2	“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар ирүүлсэн Ш.Дашдорж, О.Улаанхүү нарын тодорхойлолт хэлэлцэх	“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар ирүүлсэн Ш.Дашдорж, О.Улаанхүү нарын тодорхойлолтыг хэлэлцээд шагналын шаардлага хангаж байгаа тул холбогдох материалыг бүрдүүлэн Төрийн албан зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.
3	Аймгийн ИТХ-ын ажлын албаны сул орон тоог нөөцөөс нөхөх тухай	Аймгийн ИТХ-ын ажлын албаны Төсөв, санхүү, шагнал, иргэний танхим хариуцсан ажилтны албан тушаалд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд 68,6 оноо авч, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 146 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Мягмар овогтой Нандинцэцэгийг томилуулахаар нэрийг дэвшүүлэхээр шийдвэрлэв.
4	Дэлгэрхангай сумын иргэн Р.Мөнхцэцэгийн өргөдлийг хэлэлцээд төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэх тухай	Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст орлого, шимтгэлийн байцаагчаар ажиллаж байгаад гэр бүлийн хүнээ асрах шалтгаанаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөн тус аймгийн Дэлгэрхангай суманд оршин суугаа Рэнчиндавга овогтой Мөнхцэцэгийг Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэх тогтоол гаргахаар болов.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА